



УЛААНБААТАР ХОТЫН БАЯНГОЛ ДҮҮРЭГТ ОРШИХ
“МОНОС КОСМЕТИК ХХК-НИЙ ГОО САЙХНЫ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН
ШААРДЛАГАТАЙ ХИМИЙН БОДИСЫГ ИМПОРТЛОХ,
АШИГЛАХ ТӨСӨЛ”-ИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР:2091054/



ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....2

1.1 Төслийн нэр:.....2

1.2 Төсөл хэрэгжүүлэгч2

1.3 Байгууллагын товч танилцуулга2

ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ4

2.1 Дэд бүтэц

2.2 Хүчин чадал4

2.3 Үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалт4

ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ.....7

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ.....10

4.1 Хамрах хүрээ.....11

4.2 Зорилго.....11

4.3 Зорилт.....11

4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....12

4.5 Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө14

4.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....14

4.7 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө14

4.8 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө14

4.9 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө15

4.10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө17

4.11 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө18

4.12 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр19

ТАВ. 2026 ОНЫ БОМТ-НИЙ НИЙТ ЗАРДАЛ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Тоног төхөөрөмжийн жагсаалт.....5

Хүснэгт 2 Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах8

Хүснэгт 3 Төслийн үйл ажиллагаанаас гарах сөрөг нөлөөллийн магадлан жагсаалт.9

Хүснэгт 4 2024 оны БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн11

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Төслийн талбайн байршлын зураг2

Зураг 2 Компанийн түүхэн замнал3

Зураг 3 Компанийн үйлдвэрийн байр3



НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн нэр:

“Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах”

1.2 Үйлдвэрийн байршил:

“Монос косметикс” ХХК-ийн “Гоо сайхны үйлдвэр” төс байршил Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороонд байрладаг. Эзэмшлийн газрын нийт хэмжээ нь 3200м² талбайд байрлаж байна.

Улсын бүртгэлийн дугаар: 9011013080

Регистрийн дугаар: 2091054


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголон /18130/, Товчооны зам 4Б

Газрын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо |Сонсголонгийн зам

Утас: 77373737, 99942525

Төсөл хэрэгжих байршил, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Үйлдвэрийн баруун бүс /16103/, Сонсголонгийн зам

Зураг 1 Төслийн талбайн байршилын зураг



1.3 Товч танилцуулга

Алсын хараа: “Хэрэглэгч таны эрэлт хэрэгцээнд нийцсэн гоо сайхны чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дэлхийд танигдсан монгол брэндийг бүтээнэ.”


Компанийн эрхэм зорилго: “Бид инноваци, дэвшилтэт технологи шингэсэн гоо сайхны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, салбарынхаа хөгжлийг тодорхойлогч, тэргүүлэгч нь байх болно.”

Нэгдсэн менежментийн бодлого: “ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭГ ДЭЭДЛЭН ЧАНАРЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, СТАНДАРТ ШААРДЛАГУУДЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨЖ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН, ДЭВШИЛТЭТ

“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ТЕХНОЛОГИ, МЭДЛЭГТ ТУЛГУУРЛАСАН ГОО САЙХНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛЖ АЖИЛЛАНА

Зураг 2 Компанийн түүхэн замнал



Зураг 3 Компанийн үйлдвэрийн зураг



ХОЁР. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ, ХҮЧИН ЧАДАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

2.1 Дэд бүтэц

1. **Зам харилцаа:** “Монос косметикс ” ХХК нь Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Сонсголонгийн зам дагуу төв авто замаас 0.5 км орчим зайд сайжруулсан шороон замаар холбогдсон байрлалд байрладаг.
2. **Цахилаан хангамж:** Монос хүнс ХК-тай гэрээлэн дулаанаа авдаг. Монос хүнс ХК нь ДЦС-тай гэрээлэн цахилгаан дулаанаар хангуулдаг. Гэхдээ цахилгааны эх үүсвэр нь төвийн цахилгаан эрчим хүчээр хангагддаг.
3. **Усан хангамж:** Усан хангамжийг Монос фарм ХХК-тай гэрээлэн ашиглаж байгаа. Монос фарм ХХК нь Ус сувгийн удирдах газартай цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир татан зайлуулах гэрээтэй.

2.2 Хүчин чадал

Төслийн хүрээнд нийт 150 ажилтан ажиллана. 200 нэр төрлийн 14000-16000 ширхэг бүтээгдэхүүн өдөрт үйлдвэрлэх хүчин чадалтай.

2.3 Үйлдвэрийн удирдлага, зохион байгуулалт

Төслийн үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтад мөрдөн ажилладаг стандарт журам , заавар боловсруулалт сайтай. Мөрдөн ажиллах журам 41, стандарт ажлын заавар 63, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой ажлын заавар 132, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой мөрдлөг болгон ажилладаг гадны гаралтай бичиг баримт буюу Монгол Улсын 21 стандарт гэх мэт баримт бичгийг боловсруулан мөрдөн ажилладаг.

- Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 сиандартыг 2017 онд
- Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015 стандартыг 2020 онд
- Үйлдвэрийн зохистой дадал GMP стандартыг 2022 онд тус тус нэвтрүүлсэн.
- БНСУ-ын ДЭГҮ их сургуулийн дэргэдэх гоо сайхны судалгаа , хөгжлийн лабораторитой хамтран бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгаа шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэж ажилладаг.



Хүснэгт 1 Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Зураг	Хүчин чадал	Зориулалт
1	Детергент найрлагын тогоо	2		Багтаамж: 500л	Мециллар ус, Гар ариутгагч, Шампунь, Шингэн саван гэх мэт детергент бүтээгдэхүүний найрлага хийх
2	Вакум эмульс үүсгэгч найрлагын тогоо	1		Багтаамж: 200л	Тос, тосон бүтээгдэхүүний найрлага хийх
3	Вакум эмульс үүсгэгч найрлагын тогоо	1		Багтаамж: 100л	Тос, тосон бүтээгдэхүүний найрлага хийх
4	Автомат савлах машин	1		Цагт: 1200-4800ш	TUBE-р савлах
5	Хагас автомат Савлах машин	3		2100ш/цагт	Бэлэн бүтээгдэхүүн дүүргэх

6	Хагас автомат Савлах машин	3		Цагт: 600-1800ш	Бэлэн бүтээгдэхүүн дүүргэх
7	Хагас автомат Савлах машин	1		Ажиллах хүчин чадал: 40-120 ш/мин	Бэлэн бүтээгдэхүүн дүүргэх
8	Нэг удаагын сачёт савлах машин	1		Цагт: 1200-3000ш	Нэг удаагын савлагааг дүүргэж нааж гаргах зориулалттай
9	Лазер болон Бэхэн он сар дарагч машин	3		8000мм/сек	Он сар дарагч
10	Уураар агшаах машин	1		600м/цаг	Сав гялгар уутаар бүрэх машин
11	6 Meters belt conveyor	4		6м	Бэлэн бүтээгдэхүүн дамжуулах конвер
12	Блистер бүрэх машин	1		Цагт: 600-3000	Хайрцагтай бүтээгдэхүүн гялгар уутаар бүрэх машин
13	Хийн компрессор	1		8.38 m3/min	Шахсан хий хураах

14	<i>trough Powder Mixer</i>	1		100л	<i>Нунтаг бүтээгдэхүүний найрлага холих тогоо</i>
15	<i>Vertical piston pump</i>	2		1000мл	<i>Нөөцийн савнаас хагас автомат дүүргэх машин руу бэлэн бүтээгдэхүүн дамжуулах насос</i>
16	<i>Rotor Pump</i>	1		4.5-5m ³ /h	<i>Найрлагын тогооноос бүтээгдэхүүн нөөцийн танк руу дамжуулах насос</i>
17	<i>Chiller 2 hp</i>	1		2HP	<i>Бүрэн автомат туба сав дүүргэх машины хөргөлт</i>
18	<i>Ус цэвэршүүлэх төхөөрөмж</i>	1		500л/ц	<i>2 шатлалт мембранаар ус шүүх</i>
19	<i>Агааржуулалтын систем</i>	1		26500 m ³ /h,	<i>ЖМП бүсийн агааржуулалтын сэлгэн түгээх, цэвэршүүлэх</i>
20	<i>Industrial Air Cooling Type Water Chille</i>	1		30HP	<i>Найрлагын цехийн тогоонуудыг давхар цамцаар дамжуулан хөргөх үүрэгтэй</i>
21	<i>Нунтаг пүдөр найруулах машин</i>	1		8л	<i>Пүдөр зуурах зориулалттай</i>
22	<i>Шошго наах машин</i>	1		Цагт: 1200-3000ш	<i>Бөөрөнхий саван дээр шошго наах зориулалттай</i>



ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

“Монос косметикс” ХХК-ийн “Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах ” төсөл хэрэгжиж байгаа Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэт учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв. Уг төсөл нь төлөвлөлтийн хугацаа буюу ойрын 5 жилдээ хэрэгжихээр төлөвлөгдсөн ба цаашдаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бол тухайн үеийн байгаль орчны эрх зүйн асуудлын хүрээнд нэмэлт тодотгол байдлаар нөлөөллийг үнэлэх нь илүү зохистой. Энэхүү үнэлгээнд төсөл хэрэгжих 5 жилийн хугацаанд байгаль орчны нийгмийн нөлөөллийг тодорхойлох зорилготой.

Хүснэгт 2 Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газар доорх урсцын өөрчлөлт										
Газар доорх усны чанарын өөрчлөлт		х			х					х
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х				х	
Геологийн тогтцын өөрчлөлт										
Зэрлэг амьтдын орон зай		х		х			х			х
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х		х						х
2.Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал										
Эрдэс түүхий эдийн нөөц										
Эрчим хүчний нөөц	х			х			х		х	
3.Байгаль орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	х			х		х				х
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	х		х	х						х
Хөрсний эвдрэл, бохирдол	х			х			х		х	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		х	х		х		х		х	
Дуу чимээ, шуугианы нөлөө		х		х						х
4.Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх										
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх										
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										



“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
5.Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x			x						x
Орон нутгийн орлого нэмэгдэх	x			x						x
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x						x
Ажлын байр нэмэгдэх	x			x						x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x					x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x					x
Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x			x			x			x
Ахуйн бохир ус, химийн бодис хөрсөнд нэвчиж, хөрс бохирдуулах		x			x		x			x
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах , шавж үржих	x			x		x			x	
Хүчтэй салхи , түймэр газар хөдлөл, аянга	x			x			x	x		
Дүн	14	8	2	15	6	2	8	1	7	13

Байгаль орчны үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг түүний хэлбэр, үргэлжлэх хугацаа , нөлөөллийн эрчим зэргийг уялдуулан нийт 32 асуулгаар тодорхойлох гэж тодорхойлох гэж оролдов. Төсөл хэрэгжих хугацаандаа богино хугацааны , эрчим багатай, шууд нөлөөлөх нөлөөлөл давамгайлхаар харагдаж байна.

Хүснэгт 3 Төслийн үйл ажиллагаанаас гарах сөрөг нөлөөллийн магадлан жагсаалт

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй	Нөлөөллийн эрчим		
			Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбогдон гарах нөлөөлөл					
1	Хүн ам нүүлгэн шилжүүлэх асуудал	0			
2	Тусгай хамгаалалттай бүс нутгийн ховор, ховордсон биологийн төрөл зүйлийн амьдрах орчин	0			
3	Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдворт газрыг эвдэхэд хүргэх	0			
4	Ой модыг огтлох, гэмтээх асуудал	0			
5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	0			
6	Булаг шандын усны горимд өөрчлөлт орох ба хатаж ширгэх аюултай эсэх	0			
7	Голын голдирол эвдэж өөрчлөх эсэх	0			
8	Байгалийн эрдэс баялгийг ашиглах эсэх	0			
2.Төслийн шийдэлтэй холбогдол бүхий нөлөөлөл					
9	Үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцтэй эсэх	+	+		
10	Төслийн үйл ажиллагаанд тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, химийн бодис хэрэглэх				
11	Төслийн үйл ажиллагаанд сонгосон техник, тоног төхөөрөмжийн шийдэл , түүхий эд нь байгалийн баялаг орчинд хэр нийцтэй эсэх	+			
3.Төслийн үйл ажиллагаанд холбогдол бүхий нөлөөлөл					
12	Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх	+		+	



“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

13	Хөрсний элэгдэл , эвдрэлийг бууруулах орчныг тохижуулах төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан эсэх	+	+		
14	Төслийн үйл ажиллааны нөлөөгөөр хөрс, ургамал талхлагдах эсэх				
15	Төслийн байгууламж хоорондын хөрсний бохирдлыг багасгах талаар төлөвлөгөөнд тусгагдах эсэх	+	+		
16	Төслийг хэрэгжүүлэхэд орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлөх	+	+		
17	Ядуурлыг бууруулах	+	+		
18	Эдийн засгийн өсөлт	+	+		
19	Онцгой нөлөөлөл	0			

Тайлбар:

(0) Нөлөөлөлгүй

(-) Сөрөг нөлөөтэй

(+) Эерэг нөлөөтэй

-	2	10.5%
+	8	42.1%
0	9	47.3%

Дээрх нөлөөллийн үнэлгээнээс тооцож үзвэл энэ төсөл байгаль орчинд нөлөөлөх байдлаараа сөрөг нөлөөлөл 10.5% ийн нөлөөллийн эрчим “Дунд”, эерэг нөлөөлөл 42.1% эрчим нь “Бага” байх нөлөөтэй байхаар байна.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Улаанбаатар хот Баянгол дүүргийн 20-р хороонд байрлах “Монос косметик” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Тоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох , ашиглах” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, Байгаль орчны менежментийн 5 жилийн батлагдсан төлөвлөгөө зэрэгт тулгуурлан боловсруулав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.



4.1 Хамрах хүрээ:

Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс хамгаалах, эвдрэл элэгдэлд орохоос сэргийлэн ажиллахаар төлөвлөнө.

4.2 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, байгаль орчны төлөв байдлын тайланд тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

4.3 Зорилт

- 1. БОТБТ-гаар тодорхойлогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэн, бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
- 2. Харьяа хороо, дүүргийн иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцлийг бүрдүүлж хамтран ажиллах
- 3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана
- 4. Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хийж, ногоон орчныг нэмэгдүүлнэ.

Хүснэгт 4 2024 оны БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Тухайн жилийн зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,138.000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө/ногоон байгууламжийн төлөвлөгөө/	1,200.000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, Химийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	850.000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11,718.000
8	Удирдлага зохион байгуулалт	40.000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	690.000
Нийт		15,636.000

4.4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1. Агаар орчин									
1	Агуулах болон төслийн орчинд үйл ажиллагаанаас үүдэн агаарын бохирдол үүсэх	Агуулах болон Төслийн байршилд агаарын бохирдолд хяналт тавьж жилд 2 удаа шинжилгээ хийлгэх /2цэгт/	Агуулах болон Төслийн орчин	Жилд 2 удаа	35.000	2 цэгт 2 удаа	140.000	6 сарын 25-30 11 сарын 25-30	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын тухай хөтөлбөрийн хууль
2	Орчны тоосжилт үүсэх	Орчны тоосжилт үүсгэхгүй байхад анхаарч, ил гарсан хөрсийг зүлэгжүүлэх	Төслийн эзэмшил газарт	1 удаа	30.000	1 цэгт	30.000	6 сарын 29-30	
2. Дуу чимээ									
3	Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	1. Машиныг агуулахын байршилд байршуулах 2. Төслийн тоног төхөөрөмжийг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нормын дагуу зөв байршуулж, зөв зааврын дагуу ашиглах /ХАБ/	Агуулах болон Төслийн орчин	Жилд 1 удаа	50.000	50.000	50.000	Тогтмол	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүү ахуй, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO дагуу 226:2003 дуу чимээ, хэвийн норм - түвшиний хэмжээ
4		Ажиллагсдыг дуу шууганаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсдад	Жилд 1 удаа	8.000	жил бүр	24.000	Жил бүр 3 хүн	
5		Дуу шуугианы хэмжилтийг хийлгэх (Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори)	Агуулахын байранд, хашаанд	Жилд 1 удаа	8.000	2 цэгт	24.000	1 цэгт	
3. Усны нөөц, чанар									
6	Төслийн явцад газрын гадарга, гүний ус бохирдуулах шууд бус нөлөөлөлтэй	Усны бохирдол үүсгэхээс урьдчилан сэргийлэх, усны шинжилгээг тогтмол хийх, хөндлөнгийн шинжилгээгээр хянуулах бохирдол үүсэж буй эсэхийг хянах	Төслийн хүрээнд	Жилд 1 удаа (Технологи, хаягдал болон ундны ус)	279.000	3 цэгт	337.000	Төслийн бүхий л үйл ажиллагаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль

4. Хөрс, ургамлын бүрхэвч									
7	Ахуйн бохирдол үүсэх	Агуулах, лабораторийн байрны гадна хог хаягдлыг хадгалах зориулалтын битүүмжилсэн хогийн савны сайжруулалт хийх, ангилан ялгалттай болох	Агуулах өөрийн эзэмшил талбайн хогийн цэгт	Эхний 2 жилд	500.000	-	500.000	2026 оны 09 сарын 20	MNS 33075:1991, MNS 3308:1991 Хөрс, Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
8		Хатуу хог хаягдлыг оффис, агуулах, болон төслийн байршилд тогтмол ангилан ялгах, хог хаягдлын нэгдсэн цэгт байршуулах, дахиварын цэгт тушааж байх	Төслийн хүрээнд	Сар бүр	300.000	-	300.000	Тогтмол	
9	Ажиллагсдын санамсаргүй болон хөдөлмөрийн орчин бүрдээгүйн улмаас Химийн бодис асгах, алдагдах хөрсөнд бохирдол үүсэх	1. Агуулахад бодисын асгаралтаас хамгаалах тавиуртай болох, хөдөлмөрийн зохистой орчин бүрдүүлэх (Бодис зөөх, тээвэрлэх) 2. Аюултай хог хаягдлыг тусгайлсан түр хадгалах хогийн цэг гарган хадгалах	Агуулах, төслийн хүрээнд	Эхний 2 жилд	400.000	-	400.000	2026 оны 09 сарын 10-15	
10	Химийн бодис болон ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох	Хог хаягдлын ангиллыг менежментийн түвшинд боловсруулж, түүний дагуу тогтмол хэрэгжүүлэх, ажилчдыг мэдлэгжүүлэх, сургалт зохион байгуулах	Төслийн талбайд	Эхний 3 жилд	50.000		50.000	2026 оны 05 сарын 18	
Нийт							1,855.000		

“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.4.2 НӨХӨН СЭРГЭЭЛТ /ногоон байгууламжийн төлөвлөгөө/								
№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш/	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Нөхөн сэргээлт	“Тэрбум мод үнэсний хөдөлгөөн”-ий хүрээнд харъяа хороо, дүүрэгтэй хамтран төлөвлөлттэйгээр мод тарих, арчлан ургуулах. (Группийн шийдвэрээр нэгдсэн мод тарьдаг.)	Жил бүр	50	12.000	600.000	05 сарын 15 эсвэл 09 сарын 15	MNS 5914-2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.Нэр томъёо, тодорхойлолт.
2		Орчны ногоон байгууламжтай талбайд цэвэрлэгээ хийх, зүлэгжүүлэх, сайжруулалт хийх	Жил бүрийн Хавар	1	600.000	600.000	2026 оны 06 сарын 20-25	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
3		Нийтийг хамарсан цэвэрлэгээнд оролцох	Удаа	1	100.000	100.000	2026.03.10-13	
Нийт						1,300.000		

4.4.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, үйлдвэрлэлийн бүсэд байрлах дүйцүүлэх хамгаалах төлөвлөгөө тусгагдах шаардлагагүй болно. Гэхдээ сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд ногоон байгууламж бий болгох , мод тарих ажлыг тусгаж өгсөн болно.

4.4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө тусгагдах шаардлагагүй болно.

Төслийн талбай нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо ,үйлдвэрлэлийн бүсэд байрлах учир нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдах шаардлагагүй болно.

4.4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн талбай нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо ,үйлдвэрлэлийн бүсэд байрлах бөгөөд Улаанбаатар хот үүссэн цагаас олон жил ашиглагдаж байгаа газар , талбай юм. Тиймээс төслийн талбай нь түүх , соёлын өвтэй холбоотой дурсгалын эд зүйл илрэх боломжгүй хэсэгт оршиж байна.

4.4.6 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төсөл								
№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ Химийн бодистой холбоотой үүсэх осол ба эрсдэл	Техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	Эвдрэл гарах бүрт	-	300.000	Тогтмол	Гамшигаас хамгаалах тухай хууль, 27.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай.
2		Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	1 удаа	100.000	100.000	2026.05.08	
3		Химийн бодистой харьцаж ажиллах ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт зохион байгуулах	Химийн бодистой харьцан ажиллагсдад	1 удаа	150.000	150.000	2026.01.10	
5		Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (GMP шаардлагын дагуух ажилчдын хувцас) хангах	Төслийн хэмжээнд	Алба тус бүр (шаардлагатай ажилчид)	5 алба	270.000	Жил бүр	
6		“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай” хуулийн 31.2 т “Шинээр ажлын байр бий болгох болон ажлын байрны үйлдвэрлэл үйлчилгээний чиглэл өөрчлөгдөх бүрд, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын	Төслийн хүрээнд	1 удаа	-	600.000	2026.10.19-23	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэнэ” гэсэн заалтын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж байх							
	Нийт				1,420.000				

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах үүднээс ахуйн болон үйлдвэрийн гаралтай хатуу, шингэн, хог хаягдалыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар хэрхэн цуглуулж, ангилан, дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг төлөвлөж дараах компаниудтай хог хаягдлын гэрээ хийсэн.

№	Хог хаягдлын төрөл		Жилд гарах баримжаа хэмжээ	Хаягдал хүлээн авах гэрээт компани
1	Устгах дахин ашиглах боломжгүй хог хаягдал	Ангилан ялгах боломжгүй ахуйн хог хаягдал	70тн	Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ
2		Хаягдал бор хайрцаг	8 тн	Түмэн шувуут сав баглаа боодлын үйлдвэр
		Ялгасан бор хайрцаг		Эко Орчин ХХК
3	Дахин ашиглах боломжтой энгийн хог хаягдал	HDPE хуванцар сав, PP хуванцар таг	1тн	Хэв хашмал ХХК
4		PET1 хуванцар сав	100кг	Ти Эм Эл Пластик ХХК
5	Аюултай хог хаягдал	Химийн бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол, шингээгч, бохир алчуур, фильтрийн материал, ажилласан тос	2 тн	Элемент ХХК
6		Микробиологийн шинжилгээний нэг удаагийн хэрэгсэл	250кг	Элемент ХХК

Монос косметик ХХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн жил ирэх бүр үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлд ажиллаж байна. Үүний хүрээнд хог хаягдлын хэмжээ энэ үеийн өмнөхтэй харьцуулахад 40-60% -иар бууруулсан байна. Бид хог хаягдаа дахивар болон идэвхгүй хаягдал зэргээр дөрвөн төрөлд ангилж, цааш нь дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч болон дахин боловсруулах компаниудад нийлүүлдэг. Нийт компанийн хэмжээнд хугацаа нь дуусч актлагдаж буй бүтээгдэхүүнүүдийн хувьд тогтворжилтын судалгаа хийснээр 2024 оноос хойш 127 нэр төрлийн бүтээгдэхүүнээс **8 төрлийн бүтээгдэхүүн (12 сар), 12 төрлийн бүтээгдэхүүн (24 сар), 27 төрлийн бүтээгдэхүүн (36 сар)** болгож өөрчилсөн бөгөөд энэ нь хог хаягдлын менежментийн тогтолцооны хувьд маш том өөрчлөлтийг авчирсаар байна. 2026 онд хог хаягдлын ангилан хаялтыг нэмэгдүүлэх зорилгоо дахин сэргээж компанийн нийт ажилчдын дунд хог хаягдлын менежментийн сургалт орж мэдлэгжүүлэх, ингэснээрээ ангилсан хог хаягдлыг дахин боловсруулалтанд шилжүүлэн ландфиллд хаягдах хог хаягдлын хэмжээг бууруулахаар зорин ажиллана.

“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4.4.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хатуу хог хаягдал их үүссэнээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ангилах, дахин боловсруулалтанд оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүр	350.000	Жилд 1 удаа	350.000	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
2	Аюултай хог хаягдал ба ахуйн хог хаягдал холилдох	Химийн бодис, шингэн хог хаягдал асгарсан тохиолдолд тухай бүрд нь арилгаж байх материалыг /элс, хаягдал зориулалтын шингээгч даавуу гэх мэт/ нөөц бэлдэх	Төслийн хүрээнд	Жилд 1 удаа шалгах, дутуу хэрэгслийг нөхөх	500.000	Жилд 1 удаа	500.000	Жил бүрийн 09 сард	
3		Аюултай хог хаягдал хадгалах түр цэг байгуулах	Төслийн хүрээнд	1 удаа	2,750.000	Жилд 1 удаа	2,750.000	Эхний 2 жилд	
4		Аюултай хог хаягдлыг хаягдал боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд	Тухай бүр	8,018.000	12 удаа	8,108.000	Сар бүр	
5	Химийн бодисын ууршилт үүсч агаар орчин бохирдож болзошгүй. /Бодисын шуудай, асгарсан бодис урвалж арчсан материалууд/	Худалдан авагч байгууллагуудтай гэрээлэн химийн бодисын битүүмжлэлийг сайжруулах, химийн бодисын савыг тусгай зөвшөөрөлтэй газарт тушаах	Төслийн хүрээнд	Тухай бүр	100.000	Тухай бүр	100.000	Жил бүр	
Нийт					11,808.000				

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монос Косметик ХХК нь 2026 оноос Нэгдсэн менежментийн багийг шинээр зохион байгуулж, компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй Нэгдсэн менежментийн тогтолцоогоо илүү ойлгомжтойгоор менежрийн түвшний ажилчдын түвшинд мэдлэг, мэдээллийг түгээж, түүнчлэн ажилчдын мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэх, чиглүүлэх ажилчдаар өөрсдөөр нь Нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэлийг гүйцэтгүүлэх замаар хамрах цар хүрээг илүү хүртээмжтэй болгох зорилгоор ажиллаж байна.

Энэхүү удирдлагын зохион байгуулалттай холбоотой бүхий л сургалт, мэргэшүүлэлттэй холбоотой зардлууд нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсөвт тусгагдсан бөгөөд тус төлөвлөгөөний дагуу 14 дотоод аудиторыг 2026 оны 05 сард бэлтгэн амжилттай хэрэгжүүлээд явж байна.

4.4.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө							
№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, /мян.төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Нийслэлийн байгаль орчны газарт	Цаасан болон цахим хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилт болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийн тайлан	Жил бүрийн 11 р сарын 01 ны дотор	40.000	Чанарын менежер	-
2	БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Цаасан тайлангаар /цахим тайлан/	БОМТ болон Хяналт, ыншинжилгээний гүйцэтгэлийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 15 ны дотор	--	Чанарын менежер	
Нийт					40.000		

ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Монос косметик” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

5.1 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /мян.төг/	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар								
1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Агуулахын байр, Үйлдвэрийн байр тус бүрд 1 цэг сонгох	2026 он 06 сарын 30 11 сарын 30	Жилд 4 удаа	55.000	220.000	Нэг удаадаа 2 өөр цэгээс	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 49905:2010, MNS 0017-2-3-165:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм
Усны чанар								
2	Ажилчдын ахуйн хэрэглээ, ундны усны дотоодын хяналт	Төвийн шугам болон ундны ус	2026 он 05 сарын 01 11 сарын 01	Жилд 2 удаа	115.000	230.000	Дотоод хяналтын лабораторид тогтмол хянах	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 13.060.50 Усны чанарын стандарт
Хөрсний бохирдол								
3	Хөрсний төлөв байдал, бохирдол:	Төслийн талбай болон агуулахаас тус бүр 1 цэг сонгох	2026 он 05 сарын 15 11 сарын 15	Жилд 2 удаа	120.000	240.000	2 цэгт, 4 дээжинд хяналт хийх	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Нийт					690.000			

“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ТАВ. 2026 ОНЫ БОМТ-НИЙ НИЙТ ТӨСӨВ /ҮАЗ орсон/

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний задаргаа	2026 оны жилийн төсөв /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,855.000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө/ногоон байгууламжийн төлөвлөгөө/	1,300.000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, Химийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,420.000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	11,808.000
8	Удирдлага зохион байгуулалт	40.000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	690.000
Нийт		17,113.000

ТАВ. ДҮГНЭЛТ

Монос косметик ХХК нь 2021 оноос Олон Улсын Гоо сайхны үйлдвэрлэлийн GMP шаардлага хангасан шинэ үйлдвэрийн төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын үндэсний гоо сайхны үйлдвэрлэгчийн түүхийг бичилцэж, өнгөрсөн хугацаанд явуулсан бодлого, үйл ажиллагаа, бүтээн байгуулалт болон олсон ололт, гаргасан амжилт, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтээрээ ямагт салбартаа тэргүүлж ирсэн.

Үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа түүний нөлөө нь байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй ээлтэй байлгах, байгалийн нөөцийг зөв зохистой хэрэглэх, байгаль орчинд үлдэх ул мөрөө бага байлгах зорилгоор олон улсын стандартад нийцүүлэх зорилтын хүрээнд Чанарын менежментийн тогтолцооны стандарт ISO9001:2015-ийг 2017 онд, Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO14001:2015 стандартыг 2020 онд нэвтрүүлж, 2026 оноос Нэгдсэн менежментийн тогтолцоотой болж чанар, бүтээмж, менежментээ ямагт сайжруулан ажиллаж байна.

Бид 2024 онд Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэж 2026 ондоо 15,636.000 дүн бүхий төлөвлөгөө батлуулж байсан бол үйл ажиллагаатай холбоотой гарах зардлуудаа тодорхой болгож, инфляцийн өсөлттэй холбоотойгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө нийт 17,113.000 дүн төсөвлөж байна. Бид хуулийн дагуу Байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр батлагдсан дүнгийн 50% төлбөр болох 7,818.000 төгрөгийг Нөхөн сэргээлтийн дансанд байршуулсан болно.

“Монос косметикс ХХК”-ийн Улаанбаатар хотын Баянгол дүүрэг, 20-р хороонд хэрэгжих “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон шаардлагатай химийн бодисыг импортлох, ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Байгаль орчны менежмент нь МОНОС КОСМЕТИК компанийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байх ба дараах зарчмуудыг баримтлана.

1. Байгалийн нөөцийн (эрчим хүч, ус дулаан, цаас) ашиглалтдаа хяналт тавьж үр ашигтай ашиглах замаар нөөцийг арвилан хэмнэнэ.
2. Байгаль орчинд ээлтэй, ногоон дизайныг бүтээгдэхүүн үйлчилгээндээ нэвтрүүлнэ.
3. Байгаль орчинд ээлтэй хамт олон болоход хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тогтмол сургалтыг зохион байгуулж, зохистой зөв дадлыг хэвшүүлнэ.
4. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, дахиврыг ашиглах боломжийг бий болгоно.

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОРИЛТ

1. НОГООН ДАДАЛ БИЙ БОЛГОХ

- а) Нэгж бүтээгдэхүүний уурын хэрэглээг 1200 кЖ-с хэтрүүлэхгүй байх
- б) Ус цэвэршүүлэх системээс гарсан 500 тонн хатуулагтай усыг дахин ашиглах

2. НОГООН ХУДАЛДАН АВАЛТЫГ ДЭМЖИХ

Багадаа 1000 ширхэг сав баглаа боодлын савыг дахин боловсруулах зориулалтын цэгт хүлээлгэн өгөх

3. НОГООН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ

Нийгмийн хариуцлагын хүрээнд оффис болон үйлдвэрийн талбайг ургамалжуулах

4. НОГООН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайланг хугацаанд нь боловсруулж хэрэгжилтийг хангах

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Монос Косметик ” ХХК-ийн “Тоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэр” нь 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтад заасан үйлдвэрлэлийн төслийн хэсгийн аргачлалд нийцүүлэн боловсрууллаа.

БАТЛАВ

"МОНОС КОСМЕТИК" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Э.ДАГВАБААСАНСҮРЭН/

БАТЛАВ

"ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Л.ДАВАА /

ДАХИВАР ХАЯГДАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2026 оны 4 сарын 15 өдөр

SESL-26/51

Улаанбаатар хот

Энэхүү хуванцар сав нийлүүлэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас,

"Эс И Эс Эл СМАРТ СОЛЮШН" ХХК (РД:6990916) (цаашид "Худалдан авагч" гэх), түүнийг төлөөлж Харилцагч хөгжүүлэх мэргэжилтэн Идэрзаяа

Нөгөө талаас,

"Монос косметик" ХХК (РД:2091054) (цаашид "Нийлүүлэгч" гэх), түүнийг төлөөлж тус Чанарын мэргэжилтэн Г.Ариунзаяа (хамтад нь "Талууд" гэх) нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Хамтын ажиллагааны зорилго нь хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, байгалийн нөөцийг хэмнэн, үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэхэд оршино.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь худалдан авагч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО, ХУГАЦАА

- 2.1 Нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагаанаас гарсан дахивар хог хаягдлыг PET1 тэмдэглэгээ бүхий PET1 тэмдэглэгээтэй гоо сайхны бүтээгдэхүүний тунгалаг хуванцар сав гэсэн төрлөөр тус тус ангилан цуглуулж хүлээн авагчид нийлүүлнэ.
- 2.2 **Нийлүүлэгчийн үйл ажиллагааны чиглэл:** Гоо сайхны үйлдвэрлэл
- 2.3 а. Хуванцар савны 1кг үнэ 400 (дөрвөн зуун төгрөг)
- 2.4 Нийлүүлэгч төлбөр төлөгдсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор и-баримтыг шивнэ.
- 2.5 **Төлбөр төлөх нөхцөл:** Хуванцар савыг хүлээлгэж өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.
- 2.6 **Төлбөр төлөх данс:** Нийлүүлэгчийн MN070004000452591551 тоот "Монос косметик ХХК" дансны нэртэй Худалдаа хөгжлийн банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.
- 2.7 **Гэрээний хугацаа:** Энэхүү гэрээ нь баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 2.8 Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.
- 2.9 Гэрээний төлбөрийг нэмэх, хасах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдэх бөгөөд зөвхөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төлбөрийн нөхцөл болон дүн баталгаажна.
- 2.10 Нийлүүлэгчийн хүлээлгэж өгсөн дахивар хаягдал төрлөөр ангилаагүй бол ачилт хийхгүй бөгөөд хэт бохирдсон, шингэний үлдэгдэлтэй зэргээр бохирдлын хэмжээ 1кг-аас хэтэрсэн тохиолдолд энэ талаар мэдээллийг Худалдан авагч нь Нийлүүлэгчид мэдэгдэж нийт хэмжээгээр хорогдолд тооцож төлбөрийг төлнө.

ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 **Нийлүүлэгчийн хүлээх үүрэг**

- 3.1.1 Нийлүүлэгч нь зөвхөн PET1 тэмдэглэгээ бүхий гоо сайхны бүтээгдэхүүний тунгалаг хуванцар савыг ангилан цуглуулж, хүлээлгэж өгөх бөгөөд дахиварын төрлийг холихгүй байх үүрэгтэй.
- 3.1.2 Нийлүүлэгч нь хэт бохирдсон болон зориулалтын бусаар ашигласан савнуудыг (айраг, сүү, цагаан идээний төрлийн зүйл хийсэн болон хэт бохирдсон) тээвэрлэхээс өмнө ангилан ялгасан байх үүрэгтэй.
- 3.1.3 Нийлүүлэгч нь хуванцар цуглуулах уутыг дүүргэсний дараа дуудлага өгөх бөгөөд тээвэрлүүлэхээс ажлын 2 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж ууталсан байна.
- 3.1.4 Худалдан авагчийн хүлээлгэн өгсөн хуванцарын уут, савыг зориулалтын дагуу ашиглах бөгөөд гэрээ байгуулсанаас хойш 2 сарын хугацаанд дахивараа ачуулаагүй болон гэрээ цуцлах тохиолдолд хүлээн авсан тоо хэмжээгээр буцааж өгөх үүрэгтэй.
- 3.1.5 Машинд ачих зам талбайг чөлөөлж, чөлөөтэй нэвтрэх боломжоор хангах, гэмтэж болзошгүй эд хөрөнгийг холдуулна.
- 3.2 **Худалдан авагчийн хүлээх үүрэг**
- 3.2.1 Худалдан авагч нь өөрсдийн зориулалтын төхөөрөмжөөр жинлэж баталгаажсан хэмжээгээр тооцож энэ гэрээний 2.3-т заасан хугацаанд төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 3.2.2 Худалдан авагч нь дуудлага ирүүлснээс хойш ажлын 3 хоногт тээвэрлэнэ.
- 3.2.3 Нийлүүлэгчид цуглуулах дахиварын хаягдлын талаар мэдээлэл болон гарын авлага өгөх үүрэгтэй.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1. Энэхүү гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэх бөгөөд хувь бүр адил хүчинтэй.
- 4.2. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно. Энэхүү гэрээнд хийсэн нэмэлт өөрчлөлтөд талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 4.3. Маргаан шийдвэрлэх. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.4. Гэрээ цуцлах: Аль нэг тал гэрээний хугацаанаас өмнө гэрээ цуцлах бол нөгөө талдаа ажлын 10 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ
"ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН" ХХК-ИЙН

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ
"МОНОС КОСМЕТИК" ХХК-ИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН АХЛАХ
МЕНЕЖЕР


 /О.ӨНӨРЖАРГАЛ./

Харилцагч хөгжүүлэх мэргэжилтэн:

 /Л.Идэрзаяа/
Хаяг: Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 12-р хороолол, Токио гудамж, TML оффис

Утас: 76107711, 80025829
И-мэйл: sales@tmlplastic.mn

ЧАНАР БАТАЛГААЖИЛТЫН АЛБАНЫ
ДАРГА

 /Х.ОЮУНСУВД/

Түүхий эд хариуцсан чанарын
мэргэжилтэн:

 /Г.Ариунзаяа/
Хаяг: Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрлэлийн баруун бүс, Сонсголон зам, Монос GMP цогцолбор, Монос косметик гоо сайхны үйлдвэрийн байр

Утас: 77373737, 89300202
И-мэйл: ariunzaya.ga@monos.mn

БАТЛАВ

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20
ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ
ДАРГА

Б. Бүрэлжоргол
1. Б. Бүрэлжоргол

БАТЛАВ

БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Г. ДАВААСҮРЭН

БАТЛАВ

ИРГЭН, АЖ АХУЙН
НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН
НЭР

А. Давдасансүрэн
1. Гүйцэтгэх захирал

**ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХУРААМЖ
ТӨВЛӨРҮҮЛЭХЭД ХАМТРАН АЖИЛЛАХ ГУРВАЛСАН ГЭРЭЭ**

2025 оны 10 сарын 21-ны өдөр

№ 25/169

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 **Нэг талаас:** Баянгол дүүргийн 20 дугаар хороо, 5675162 тоот регистрийн дугаартай "БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ" ОНӨААТҮГ /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, Баянгол дүүргийн 20 дугаар хороо /цаашид "Засаг дарга" гэх/.
- Нөгөө талаас:** 2091054 тоот регистрийн дугаартай, Баянгол дүүргийн 20 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах нутаг захирал чиглэлээр, нэртэйгээр үйл ажиллагаа явуулдаг (иргэн эсвэл аж ахуйн нэгж байгууллага) /цаашид "Захиалагч" гэх/ нар доорх нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2025 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөс 2027 оны 10 дугаар сарын 21-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаанд энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн дагуу Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, гэр хорооллын иргэн, аж ахуйн нэгж байгууллага /цаашид "байгууллага" гэх/-ын ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр /цаашид "хураамж" гэх/ тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.
- 1.5 Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолд заасан тарифын дагуу гэрээний үнийн дүнг тогтоосон болно.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь тогтоосон хуваарийн дагуу иргэн, байгууллага, орон сууцны бункерийн ахуйн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэх;
- 2.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол хуваарьт зааснаас бусад цагаар зохион байгуулалт хийж хог ачуулах арга хэмжээг авна.
- 2.3 Гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, нэмэлтээр барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, байгууллагын хог хаягдлын хураамж төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 2.5 Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
- 2.6 Гэрээнд заасан хугацаанд хог хаягдлын хураамжийг төлж барагдуулаагүй иргэн, байгууллагын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.

- 4.4 Хог хаягдлын цогц менежментийг бий болгон боломжит арга, технологи, байгальд ээлтэй практик нэвтрүүлэх, хог хаягдлын тухай боловсролыг иргэдэд олгох замаар зөв дадал, ухамсрыг төлөвшүүлэх;
- 4.5 Хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах санал санаачлага гаргах, хорооны нутаг дэвсгэрт үүсмэл цэг үүсэхээс сэргийлэх, тээвэрлэлтийн хуваарьтай өдөр хогоо ачуулж хэвшүүлэх ажлыг гэр хороолол бүхий хороодод зохион байгуулж, хяналт тавих;
- 4.6 Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтуудын дагуу дүүрэг, хорооноос тогтоосон "хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар"-ын хог хаягдал, цас мөсийг арилган, талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг тээвэрлүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;
- 4.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Тав. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 5.1 Гэрээт хугацаанд сард удаа иргэн, байгууллагын ахуйн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 5.2 Хог хаягдлын хураамж нь Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолд баталсан тарифын дагуу сард 300,000 төгрөг, улиралд 900,000 төгрөг, жилд 3,600,000 төгрөг байна.
- 5.3 Захиалагч нь itax.mta.mn цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэн нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө. Хог хаягдлын хураамж төлөх гэрээний 3.6-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алдангийг Захиалагч төлнө.
- 5.4 Захиалагч нь татварын itax.mta.mn цахим хаягаар хог хаягдлын хураамж төлөх төлбөрийн даалгавар үүсгэхдээ "Сум, хороо" сонгох хэсэгт: Дүүргийн төвлөрсөн төсөв, Төлбөр "хүлээн авагч байгууллага" сонгох хэсэгт: Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ-ыг тус тус сонгоно.
- 5.5 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актыг үндэслэн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үйлчилгээний үнийн тарифт холбогдох эрх бүхий байгууллагаас өөрчлөлт оруулж болно.
- 5.6 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд хог хаягдлын хураамжийг Захиалагч төлсний дараа Гүйцэтгэгч хог тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.
- 5.7 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу хог хаягдлын хураамж төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 5.8 Нийслэл, дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь өөрчлөгдөх тохиолдолд тухайн иргэн, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

Зургаа. Бусад

- 6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, авто зам хаагдах зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хог ачих боломжгүй болсон тохиолдолд Гүйцэтгэгч хариуцлага хүлээхгүй болно.
- 6.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 6.3 Тус гэрээнд дүүрэг, хорооноос тогтоосон "Хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар"-ын зураглалыг кадастр болон фото зураг хавсаргана.

- 2.7 Хог хаягдлын тухай хуульд заасан зөрчил гаргасан иргэн, байгууллагыг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж хариуцлага тооцуулах эрхтэй.
- 2.8 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал "Хог хаягдлын тухай" хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 Иргэн, байгууллага нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх;
- 3.3 Энхтайваны өргөн чөлөө, Энэбишийн өргөн чөлөө, Ард Аюуш, Занабазар, Амарсанаагийн гудамжуудын дагуух Аж ахуйн нэгжүүд хүчин чадалдаа нийцсэн HDPE материалаар хийгдсэн 240, 600 литрийн стандарт хогийн савтай байх;
- 3.4 Тээвэрлүүлэх хог хаягдлыг зөвхөн тогтоосон хог ачилтын цэг, бункерт хийх, ачилт хийхэд саадгүй байхаар орц, гарцыг төлөвлөсөн байх бөгөөд хог ачилт хийхийн өмнө хог ачилтын цэг, бункерийн орц, гарцыг чөлөөлсөн байна.
- 3.5 Иргэн, байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4.12, 10 дугаар зүйлийн 2.10 дах заалтуудын дагуу дүүрэг, хорооноос тогтоосон, "хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар"-ын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг тээвэрлүүлнэ.
- 3.6 Захиалагч тал нь гэрээний 3.2, 3.3-т заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа иргэн, байгууллагад учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.7 Хог хаягдлын хураамжийг сар бүрийн 15-аас 20-ны дотор Баянгол дүүргийн Татварын Хэлтэс болон itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэх цэсийг ашиглан үүссэн төлбөрийн даалгаварын дугаараар төлнө. Татварын лавлах 1800-1288, Баянгол дүүргийн Татварын хэлтсийн лавлах 70001288, 21254427
- 3.8 Хог ачилтын цэг, сав, бункерийн орц, гарцыг хааж автомашин болон бусад зүйл байрлуулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.9 Захиалга буюу хог хаягдал ачих, тээвэрлэх дуудлагыг 2-3 хоногийн өмнө хороо болон гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 3.10 Хог хаягдлын хураамжийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.11 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх;
- 3.12 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах;
- 3.13 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах;
- 3.14 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд үүргээ биелүүлэхийг шаардах;
- 3.15 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.

Дөрөв. Хорооны Засаг даргын эрх, үүрэг

- 4.1 Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах, эдгээр үйл ажиллагааг эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, дэмжиж ажиллах;
- 4.2 Иргэн, байгууллагад хог хаягдлын талаарх байгальд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг зүй зохистой хаях, ангилах, дахин ашиглах дадал зуршлыг төлөвшүүлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдлэгтэй болоход чиглэсэн ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- 4.3 Хог хаягдалтай холбоотой хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тооцох, тооцуулах санал гаргах;

- 6.4 Талууд аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.5 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.6 Гэрээг 3 эх хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Долоо. Нэмэлт нөхцөл

- 7.1 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолын хавсралтын хэрэгжилтийг хангах

7.2

Дуудлага

Найм. Нэмэлт өөрчлөлт

- 8.1 20 ... оны ... сарын ... ны өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах өөрчлөлтийг оруулав.

Ес. Гэрээний хавсралт

- 9.1 Хог хаягдлын хураамж төлөлтийн тодотгол 2 хуудас

Арав. Гэрээний сунгалт

- 10.1 Энэхүү гэрээг 20 оны сарын өдрөөс 20 оны сарын өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

- 10.2 Энэхүү гэрээг 20... оны ... сарын ... өдрөөс 20.. оны ... сарын ... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ байгуулсан:

20-р ХОРООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ <i>Хосгийн ахлагч</i> <i>Францэг</i> Утас: <i>9450.8978</i> Хаяг:	ГҮЙЦЭТГЭГЧ: БАЯНГОЛ ДҮҮРЭГ ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН <i>Найшир</i> <i>88047027</i> Утас: Хаяг: <i>51 гмрн</i> Баянгол дүүргийн Татварын хэлтсийн мэргэжилтэн Утас:	ЗАХИАЛАГЧ: <i>Манас Косметик ХХК</i> <i>УБД</i> Албан тушаалтай <i>Мамплаг</i> <i>Мамплаг</i> <i>Д.Фригун</i> Утас: <i>89307202</i> Хаяг: <i>БТД, 20-р хороо</i> <i>Сонгодогчдын хороо</i> <i>Монгол БМР Улаанбаатар</i> <i>Манас Косметик ХХК-н</i> <i>Фондварийн ГЗД</i>
---	---	---

БАТЛАВ. "МОНОС КОСМЕТИК" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.ДАГВАБААСАНСҮРЭН

9925410244 2091054

БАТЛАВ. "ХЭВ ХАШМАЛ ХУВАНЦАР" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.ХҮДЭРБААТАР

1111928 22 8873207

ХАЯГДАЛ ХУВАНЦАР НИЙЛҮҮЛЭХ, ХҮЛЭЭН АВАХ ГЭРЭЭ

2026 оны 04 сарын 28 өдөр

№....

Улаанбаатар хот

Нэг талаас "ХЭВ ХАШМАЛ ХУВАНЦАР" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Э.Хүдэрбаатар (цаашид "Хүлээн авагч" гэх) нөгөө талаас "МОНОС КОСМЕТИК" ХХК түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Э.Дагвабаасансүрэн (хамтад нь "ТАЛГУУД" гэх) бид "Монгол улсын иргэний хууль", "Хог хаягдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн харилцан тохиролцож дараах гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Нийлүүлэгч нь энэхүү гэрээний ХАВСРАЛТАД тусгагдсан шаардлагыг хангасан хаягдал хуванцар бүтээгдэхүүн (цаашид "Хаягдал" гэх)-г хүлээн авагчид хэсэгчлэн нийлүүлэх ба Хүлээн авагч нь ачаа дагалдах баримт бичигт заасан тоо, хэмжээний дагуу хүлээн авна. Нийлүүлэгч нь хог хаягдлыг тээвэрлэлтээс өмнө ангилан ялгах үүрэгтэй ба Хүлээн авагч нь дахин ашиглаж болох төрлийн бүтээгдэхүүн болон барилгын материал үйлдвэрлэх зорилгоор ашиглана.
- 1.2. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Хоёр. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 2.1. Нийлүүлэгч тал хуванцар хаягдал HDPE 1 кг-ыг 300 төгрөгөөр үнэлнэ. Үнэд НӨАТ орно. Модон хаягдлыг үнэлэхгүй.
- 2.2. Төлбөр тооцоог хог хаягдал барааг хүлээн авснаас хойш 7 хоногт багтааж, салбар компани тус бүр дээр НӨАТ бичиж, төлбөр тооцоог хийнэ.
- 2.3. Хүлээн авагч тал хаягдлыг тусгагчид оруулах ёстойг үндэслэн хариуцна.
- 2.4. Төлбөрийг зөвхөн энэхүү гэрээнд тусгагдсан компани тус бүрээр нэхэмжилсэний дагуу ажлын 7 хоногт багтаан дансаар шилжүүлэн төлнө.
- 2.5. Гэрээний хугацаанд гэрээнд заагдсан үнэд өөрчлөлт оруулахгүй.
- 2.6. Төлбөр төлөх данс: Нийлүүлэгчийн MN070004000452591551 тоот "Монос косметик ХХК" дансны нэртэй Худалдаа хөгжлийн банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

Гурав. Нийлүүлэлтийн нөхцөл

- 3.1. Нийлүүлэгч нь барааг ачилтад бэлэн болгохын өмнө Хүлээн авагчид барааны овор, тоо хэмжээг мэдэгдэнэ. Хаягдлын барааг 1 тонн-д хамтатгасан хаягдлын барааг хуримтлуулахыг зөвшөөрнө. Хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 3.2. Нийлүүлэх нөхцөл: Хүлээн авагч тал хог хаягдлын тээвэрлэлтийг хариуцна. Хэрэв нийлүүлэгч талын барааны хэмжээ 1 тонн-с бага бол тээвэрлэлтийг нийлүүлэгч тал хариуцна.
- 3.3. Хүлээн авагч хаягдал барааг тухай бүр тээвэрлэлтээр хүлээн авах ба ачилтыг талууд харилцан тохиролцон хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Нийлүүлэх хаягдал бараа

Бараа гэдэгт дараах төрлийн хуванцар болон модон хаягдал бүтээгдэхүүнийг ойлгоно.

- PP төрлийн төрөл бүрийн хатуу хуванцар хаягдал бүтээгдэхүүний гадны талд PP тэмдэглэгээ бүхий / подоон, хайрцаг, бөглөө, авдар, хаягдал шуудай гэх.мэт/
- HDPE төрлийн хуванцар хаягдал материалууд бүтээгдэхүүний гадна тал дээр HDPE тэмдэглэгээтэй хуванцар хаягдал, /тосны сав, химийн бодисны канистр г.м/
- PE төрлийн хуванцар материал буюу хатуу болон зөөлөн гялгар уут
- Модон подоон болон бусад модон төрлийн хаягдал

Тав. Талуудын эрх үүрэг

Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- 5.1 Нийлүүлэгч нь Хавсралт 1-т дурдсан хог, хаягдлыг зөвхөн хүлээн авагчид энэхүү гэрээний нөхцөлийг үндэслэн өөрийн талбайгаас нийлүүлнэ.
- 5.2 Нийлүүлэгч нь хог хаягдлыг аливаа _____, ялган ангилсан байна.
- 5.3 Нийлүүлэгч нь хог хаягдлыг хамгийн багаар 1 тн хэмжээгээр бөөгнүүлж, барааг ачилтад бэлэн болгох өдрийг товлж, 2-3 хоногийн өмнө хог хаягдал тээвэрлэх захиалгаа өгнө.
- 5.4 Нийлүүлэгч нь хог, хаягдлаа зохих ёсоор дахин боловсруулж байгаад хяналт тавьж болно.
- 5.5 Нийлүүлэгч хог хаягдлыг зөвхөн ажлын өдрүүдэд ажлын цагаар хүлээн авагчид нийлүүлнэ.
- 5.6 Нийлүүлэгч нь хог хаягдлыг ачих автомашинуудыг компанийн хашаа руу нэвтрэх эрхийг урьдчилж олгоно.
- 5.7 Нийлүүлэгч аливаа химийн бодисын сав болон шуудай хаягдал нийлүүлэх тохиолдолд тухайн аюултай хог хаягдлын үлдэгдлээс цэвэрлэсэн буюу үлдэгдэлгүй хаягдал нийлүүлнэ.
- 5.8 Тухайн хаягдал бараанд аюултай хог хаягдалын үлдэгдэл илэрсэн тохиолдолд Хүлээн авагч тухайн барааг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

Хүлээн авагчийн эрх үүрэг

- 5.9 Хүлээн авагч тал утсаар захиалгыг хүлээн авснаас хойш 2 өдрийн дотор хог хаягдлыг ачна. Хэрэв тухайн өдөр хүлээн авах боломжгүй тохиолдолд энэ тухай Нийлүүлэгчид урьдчилан мэдэгдэнэ.
- 5.10 Хүлээн авагч тал нь хог хаягдлыг ачиж буулгах үеийн аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, хувийн хамгаалах хэрэгсэлээр /ХХХ/ хангасан байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, журам дүрэм зөрчсөнөөс хүн бэртэж гэмтвэл Хүлээн авагч тал бүрэн хариуцна. Шаардлагатай тохиолдолд _____, Мөн тайлан баримтаар баталгаажуулж Нийлүүлэгчид хүргүүлж болно. Хүлээн авагч тал нь салбар компаниудын хариуцсан менежерүүдтэй байнгын харилцан уялдаатай ажиллана. Хүлээн авагч талтай харилцах албан тушаалтнуудын нэр, холбогдох утас албан тушаал зэрэг мэдээллийг төлбөр хүлээн авах банкны данс гэм мэт мэдээллийг энэхүү гэрээнд тодорхой тусгасан байна
- 5.11 Талууд аль нэг талын санаачилгаар гэрээг цуцлах санал гаргах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд нөгөө талдаа 14 сарын өмнө урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

Тав.Маргааныг шийдвэрлэх, Хариуцлага

- 5.1. Гэрээнд заагдсан үүргийг биелүүлэх явцад талуудын хооронд гэрээтэй холбогдон гарч болох аливаа маргааныг зөвшилцөл болон хэлэлцээрийн журмаар шийдвэрлэнэ.
- 5.2.Талууд маргааныг шийдэж чадахгүй бол аль ч тал Монгол улсын шүүхэд хандах эрхтэй.
- 5.3 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.

Зургаа. Бусад нөхцөл

- 6.1. Гэрээг Монгол хэл дээр тус бүр 2 хувь үйлдэнэ. Талууд тусбүр нэг хувийг авах бөгөөд хувиуд нь хуулийн өмнө адил хүчинтэй.
- 6.2. Гэрээ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 6.3. Гэрээний хугацаа дуусахад Талууд харилцан ямар нэг санал гаргаагүй бол гэрээ өөрөө 1 жилийн хугацаагаар сунгагдсанд тооцогдож тухайн жилдээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.4. Талууд энэ гэрээнд дурдсан өөрийн эрхийг нөгөө талын бичгээр өгсөн зовшооролгүйгээр гуравдахь этгээдэд шилжүүлж болохгүй.
- 6.6 Гэрээний хугацаа дуусгавар болсон ч Худалдан авагчаас худалдагч талд төлбөр тооцооны үлдэгдэл байгаа тохиолдолд төлбөрийг бүрэн барагдуулж дуустал энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 6.7 Энэхүү гэрээнд гагцхүү талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 6.8 Гэрээнд тусгаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу


зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НИЙЛҮҮЛЭГЧ:
“МОНОС КОСМЕТИК” ХХК
ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГА


Х.ОЮУНСУВД

ЧАНАРЫН МЭРГЭЖИЛТЭН


Г.АРИУНЗАЯА

Холбогдох дугаар: 89300202

Имэйл хаяг: arinzaya.ga@monos.mn

2026.04.28

ХҮЛЭЭН АВАГЧ:
“ХЭВ ХАШИМАЛ ХУВАНЦАР” ХХК ЗАХИРАЛ



Нийлүүлэгдэх хаягдал хуванцар бүтээгдэхүүний жагсаалт

№	Барааны нэр	Тайлбар
1	Хатуу болон зөөлөн гялгар уут	
2	PP төрлийн хатуу хуванцар хаягдал	
3	HDPE төрлийн ангилсан хуванцар хаягдал	
4	Төрөл бүрийн сав баглаа боодлын уяа	
5	Хаягдал шуудай	
6	Модон подоон	

ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

Дугаар

2026 он 04 сар 17 өдөр

Энэхүү гэрээг нэг талаас 2091054 регистрийн дугаартай МОНОС КОСМЕТИК ХХК түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал .Э.Дагвабаасансүрэн (цаашид Худалдагч гэх) нөгөө талаас 5434459 регистрийн дугаартай ЭКО ОРЧИН ХХК түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Л.Сандагсүрэн (цаашид Худалдан авагч гэх) Монгол улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр заалтыг үндэслэн дараах зүйлсийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

1. Гэрээний агуулга

1. Энэхүү гэрээнд заасны дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй барааг бэлдэж Худалдан авагчид хүлээлгэн өгөх Худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.
2. Барааны нэр, төрөл: **Картон цаасан хайрцаг /40*60, 60*60 болон түүнээс дээш хэмжээтэй/**
3. Энэхүү гэрээний Хавсралтад дурдсан графикаар барааг дурдсан хугацаанд нийлүүлсэн байна.

2. Нийлүүлэх хугацаа, нөхцөл

1. Худалдагч нь гэрээнд заасан барааг худалдан авагчид тогтвортой нийлүүлэх, барааг ачих тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.
2. Худалдагч гэрээнд заасан барааг бусад хувь хүн болон байгууллагад шилжүүлэн өгч худалдахгүй байх, зайлшгүй тохиолдолд бусдад шилжүүлэх бол албан баримт зургаар худалдан авагч талд мэдэгдэнэ.
3. Худалдагч тал картон цаасыг 1 портер хэмжээтэй болохоор худалдан авагчид дуудлага өгч ачуулах.
4. Худалдагч цэвэрхэн эвдрэл гэмтэлгүй картон цаас бэлтгэх.
5. Худалдан авагч тал барааг худалдагчийн агуулах, талбайгаас өөрийн тээврийн хэрэгсэлээр заасан цаг хугацаанд түргэн шуурхай татан авч баримтаар төлбөрийг төлнө.
6. Дуудлага бүрээр ачуулж буй картон цаасны хэмжээ болон төлбөрийн дүнг актаар баталгаажуулна.

3. Үнэ төлбөр

1. Барааны нэгжийн үнэ

Картон цаас: 1 ширхэгийн үнэ 200 төгрөг /Үнийн дүнд НӨАТ орсон/
Тээвэр /худалдагчийн тээврийн хэрэгсэлээр/

4. Төлбөр төлөх ажиллагаа болон гэрээ дуусах хугацаа

1. Худалдан авагч барааны төлбөрийг тухайн сарын 25-30-ны өдрүүдэд төлнө.
2. Төлбөрийг Худалдагч талын Худалдаа хөгжлийн банкны MN070004000452591551 тоод дансанд хийнэ.

3. Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээ нь бүрэн гүйцэтгэх хүртэл хүчин төгөлдөр байх боловч аль ч тохиолдолд 2027 оны 04 сарын 17-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.
4. Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.

5. Талуудын үүрэг хариуцлага

1. Гэрээг зөрчсөн тал нөгөө талдаа олох байсан орлогыг оролцуулан бүх холбогдох хохирлыг хуулийн дагуу төлнө.
2. Хэрэв аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлэхгүй, цуцлах саналтай байвал албан бичгээр мэдэгдэнэ.

6. Давагдашгүй хүчин зүйл

6.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2 Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

7. Маргаан шийдвэрлэх

7.1 Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

8. Гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх

1. Энэхүү гэрээний нөхцлийг талуудын хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан баримт бичгийн дагуу өөрчилж, нэмж болно.
2. Талууд нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

9. Талуудын хоорондох харилцаа

1. Талуудыг төлөөлж дараах этгээдүүдэд энэхүү гэрээтэй холбоотой асуудлаар харилцаа холбоо тогтоож, хэлэлцээ хийнэ:

Худалдагчийн төлөөлөгч: МОНОС КОСМЕТИК ХХК-ИЙН түүхий эд хариуцсан чанарын
мэргэжилтэн Г.Ариунзаяа
Утас: 89300202

Худалдан авагчийн төлөөлөгч: ЭКО ОРЧИН ХХК гүйцэтгэх захирал Л.Сандагсүрэн
Утас: 99108691

10. Тусгай нөхцөл

.....
.....

11. Бусад нөхцөл

1. Энэхүү гэрээ хоёр хувь үйлдэгдэх бөгөөд талуудад нэг нэг хувь хадгалагдана.
2. Монгол Улсын Иргэний хуулиар энэхүү гэрээнд дурдаагүй асуудлыг зохицуулна. /Энд өөр хууль тогтоомжийн актыг дурдаж болно/
3. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний өмнөх хэлэлцээр, харилцаа холбоо, зөвлөмж, санал хүчингүй болно.

12. Талуудын холбоо барих хаяг, банкны мэдээлэл

1. Худалдагчийн хаяг: БГД, 20-р хороо, Үйлдвэрлэлийн баруун бүс Монос GMP цогцолбор, Монос косметик ХХК-ийн гоо сайхны үйлдвэрийн байр
Худалдагчийн банкны мэдээлэл: Худалдаа хөгжлийн банк MN070004000452591551
2. Худалдан авагчийн хаяг: БГД, 5-р хороо, Ажилчдын гудамж, 80/1, Утас: 99053847
Худалдагч авагчийн банкны хаяг: Голомт банк 1905006672

Худалдагч:

МОНОС КОСМЕТИК ХХК

Гүйцэтгэх захирал Э.Дагвабаасансүрэн

Гарын үсэг

Тамга



Худалдан авагч:

ЭКО ОРЧИН ХХК

Гүйцэтгэх захирал Л.Сандагсүрэн

Гарын үсэг

Тамга

